



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/367

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 03/03 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Татварын багц хуулийн шинэчлэлийг таниулах, сурталчлах, “Цахимжсан татвар” ажил мэргэжлийн уралдаан, Шилдэг татвар төлөгчдөө шалгаруулан урамшуулах зардалд нийт 3,427,000 (гурван сая дөрвөн зуун хорин долоон мянга) төгрөгийн зардлыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх арга хэмжээнд шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0702

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар  
сарын 07-ны өдрийн 1130 дугаар  
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Үйл ажиллагаа	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	"Цахимжсан татвар" асуулт, хариултын уралдааны зардал	Өргөмжлөл-Асуулт хариултын тэмцээнд шалгарсан оролцогчид	3	43,000	129,000
		Оролцогчдын талархал	20	15,000	300,000
		Уралдааны байр, орчин, анонс хэвлүүлэх	1	2	100,000
		ТВ, нийгмийн сүлжээгээр сурталчлах зардал	2	50,000	100,000
2	"Хүүхдийн зургийн уралдаан"-ы зардал	ӨРГӨМЖЛӨЛ-Зургийн уралдааны хүүхдүүд	3	43,000	129,000
		Зургийн уралдааны хүүхдүүдийн ТАЛАРХАЛ	52	15,000	780,000
		Зургийн уралдааны хүүхдүүдийн шагналд	3		240,000
3	Шилдэг татвар төлөгчдөд өргөмжлөл гардуулах	Өргөмжлөл-Шилдэг татвар төлөгчид	13	43,000	559,000
		ТВ, нийгмийн сүлжээгээр сурталчлах зардал	2	50,000	100,000
		Шилдэг татвар төлөгчдөд талархал гардуулах	18	55,000	990,000
4	Нийт дүн				<b>3,427,000</b>